

## Монголын хүн амын гэрлэлтийн генетик тогтцыг судлах хэрэгцээ, шаардлага

Ц. Цэрэндаш

“Удмын хэлхээ” Төвийн тэргүүн, Хүн судлаач, доктор

Сүүлийн үед манай оронд эрдэмтэд судлаачдын төдийгүй энгийн иргэдийн ч сэтгэлийг зовоосон асуудлын нэг бол хүн амын доторхи төрөл ойртолт, түүнээс улбаатай удамшлын болон оюун ухааны хомсдолтой, биеийн хөгжлийн элдэв эмгэг согогтой хүүхдийн эзлэх хувийн жиннэмэгдэж байгаа явдал болоод байна. Хэдийгээр Монгол Улсын Төрөөс “Хүн амын удмын сангийн аюулгүй байдлыг сахин хамгаалах нь Монгол Улсын Үндэсний Аюулгүй байдлын үзэл баримтлалын нэг бүрэлдхүүн хэсэг мөн” гэж заагаад холбогдох эрхзүйн актуудыг гаргасан боловч хэрэгжилт нь төдийлөн сайнгүй байсаар өнөөг хүрлээ.

Монгол улсын хэмжээнд сүүлийн 10 гаруй жилийн хугацаанд хүн амын гэрлэлтийн төлөв байдал, генетик миграци, удамшлын болон оюун ухааны хомсдолын тархалтын судалгаа огт хийгдээгүй бөгөөд 1990-д оны эхэн ба дунд үед хийгдсэн судалгааны анхаарал татахуйц үр дүнг өнөөдөр бид жишээ болгон дурдаад сууж байгаа билээ.

Аливаа улс орны хүн амын удмын сангийн аюулгүй байдалд нөлөөлөх нэг гол хүчин зүйл бол тухайн нутаг орны хүн амын гэрлэлтийн төлөв байдал байдаг. Монголын хөдөөгийн зарим сум, багуудад гэр бүл болж буй хосуудын **68.4-99.0** хувь нь зөвхөн тухайн баг дотроо төрж өссөн хүмүүс хоорондын гэрлэлт болох нь судалгаагаар тогтоогдсон. Тэгвэл ийм байдалд хүргэх шалтгаан юу байв. Үүнд нөлөөлж байгаа хоёр гол хүчин зүйл байна. Үүнд:

**Нэгдүгээрт:** хөдөөгийн хүн амын төв суурин газар руу чиглэсэн шилжилт хөдөлгөөн. Монголын хүн амын дунд явуулсан генетик миграцийн судалгаагаар **багаас сумын төв** рүү чиглэсэн шулуун миграци сөрөг миграциасаа **0.01-280 дахин их**, тухайн **сумаас аймгийн төв** рүү чиглэсэн шулуун миграци сөрөг миграциасаа **1.6 дахин их**, **аймгуудас Улаанбаатар хот** болон **бусад үйлдвэржсэн хот суурин газар руу** чиглэсэн шулуун миграци сөрөг миграциасаа **0.03-47.4 дахин их** байгаа нь хөдөөгийн багийн хүн амын эзэлхүүнийг багасгах болсноос баг доторхи гэрлэлт ихсэх нөхцлийг бүрдүүлж, улмаар багийн хүн ам доторхи төрөл ойртолтыг өндөрсгөх нэг шалтгаан болсон байна.

**Хоёрдугаарт:** хүмүүс өөрөөсөө дээш гурван үеэс цааш удамугсаага мэдэхгүй байх тохиолдол хүн амын дунд түгээмэл байдаг нь холын хамаатан садан хүмүүс гэр бүл болох боломжтойг харуулж байна. Үүнийг ч дараах судалгааны дүн нотолж байна. Хөдөөгийн зарим сумдын хүн амын популяцид удамшлын генетик локусуудаар цаг хугацаа, орон зайн дотоод хуваагдлын шалтгаанаас үүдсэн алсуур төрөл ойртолт-ын үнэлгээг тооцож үзэхэд  $F_{ST} = 0.0058$  байгаа нь сумдын хүн ам нь 3-4 дэх үеийн ах дүүгийн хүүхдүүд хоорондын гэрлэлтээс үүссэн төрөл ойртолтын төвшинд хүрсэн үр дүн гарсан байна.

Монголын хүн амын дотор төрөл бүрийн удамшлын өвчинтэй, төрөлхийн согог, эрхтэн системийн эмгэг доголдолтой, оюун ухааны хомсдолын энгийн хэлбэрээс эхлээд усан тэнэг, сэтгэцийн элдэв гажуудалтай, оюун ухаан, сэтгэцийн хувьд эрүүл боловч аливаа хэлбэрийн мэдэгдэхүйц хоцрогдолтой хүмүүс ихсэх болсон талаар зарим хүмүүсийн сэтгэл зовнин ярьж байгаагаас дурдвал:

Хан-Уул дээд сургуулийн захирал доктор, профессор Ц.Дэмбэрэл “90-ээд оны эхээр судлаачдын тогтоосноор манай оронд оюун ухааны хомсдолын тархалт жилээс жилд ихсэж байна” гэсэн үр дүнд хүрсэн бөгөөд онолын хувьд 10000 хүнд 3 байх учиртай оюуны хомсдолын тархалтын хязгаар Монголд 10 болж, зөвшөөрөгдөх хэмжээ 3.3 дахин их байгааг тогтоосон байдаг. Энэ бол аюулын дохио мөн” гэж бичжээ.

2005 оны хавар Монгол улсын Ерөнхийлөгчийг баруун аймгуудад ажиллах үеэр хөдөөгийн нэгэн иргэн “Тус сумын иргэд ах дүүтэйгээ гэр бүл болж оюуны хомсдолтой үр хүүхэд гаргаж, урианхай ястан үгүй болоход энүүхэнд байна. Төр засаг минь анхаарлаа хандуулаач. Урианхайчууд цөөнхийн дотор цөөнх болж мөхлөө” гэж сэтгэл харуусан ярьсан байна.

Нийслэлийн сургалт хөдөлмөр сувилалын цогцолбор 25 дугаар сургуулийн согог зүйч багш, нийгмийн ажилтан (Ө.Э) “Сүүлийн жилүүдэд оюун ухааны хомсдолтой хүүхдийн тоо эрс нэмэгдэж байгаад сэтгэл ихэд эмзэглэж байна. Сүүлийн үед дэлхий нийтээр оюун ухааны хомсдолтой хүүхдийг эрүүл хүүхдийн дунд сургах тухай ярьж байгаа ч энэ нь одоогоор

манайд хэрэгжихэд хүндрэлтэй. Ийм хүүхдүүдийг ангийнхан нь гадуурхана. Үүнээс болж сэтгэлээр унаж, уруу дорой болчихдог. Тэдэнтэй ажиллах мэргэжлийн багшийн хүрэлцээ муу байгаад сэтгэл эмзэглэж явдаг” гэжээ.

Нийслэлийн сургалт хөдөлмөр сувилалын цогцолбор 70 дугаар сургуулийн согог зүйч багш, сургалтын менежер (С.Н) “Жилээс жилд оюун ухааны хомсдолын улмаас манай сургуульд хамрагдах хүүхдийн тоо эрс нэмэгдэж байгаа бөгөөд ихэнхдээ оюун ухааны хомсдолын хүнд хэлбэртэй хүүхдүүд ирж байгаа нь зүрх шимширмээр байгаа. Сүүлийн үед хөдөө орон нутгаас удамшлын өвчтэй хүүхдүүд их ирэх болсноос нэгдүгээр ангийн нэг бүлэгт 10 гаруй хүүхэд суралцаж байгаа нь тэдэнтэй ажиллаж байгаа багшид асар хүнд байдаг” гэж ярьж байна.

Хүн амын дундах төрөл ойртолт, түүнээс сэргийлэх гол арга болох угийн бичиг хөтлөлтийн талаар огт хөндөөгүй юу гэвэл үгүй билээ. Монголын хүн амын генетик тогтцыг судлах, монгол айл өрх бүрийг угийн бичигжүүлэх энэ асуудал аль эрт 17-18 жилийн өмнөөс яригдсан ч дорвитой үр дүнд хүрэхгүй, цаг хугацааг алдсаар байгаад сэтгэл эмзэглэн энэ чиглэлээр мэргэшсэн судлаачийн хувьд энэ асуудлыг хөндөхгүй байж болохгүй байна.

Дээр дурдсан жишээ баримтуудаас харахад монголын хүн амын дунд гэрлэлтийн генетик тогтоц, хүн амын төрөл ойртолтын төлөв байдал, удамшлын болон оюун ухааны хомсдолын тархалтын судалгааг цаг алдалгүй яаралтай хийх шаардлага зүй ёсоор урган гарч байна.

---

Даяаршил эрчимтэй явагдаж буй энэ эрин зуунд бид эрүүл чийрэг бие бялдартай, саруул цовоо оюун ухаантай хүн ардтай байж гэмээн дэлхийн хөгжилтэй хөл нийлүүлэн алхах болно. Иймд үе хойч, үр удмаа энэ их далайд хөл алдуулахгүйн тулд удам угсаагаа цэвэр ариун байлгах талаар анхаарах нь *бидний хойч үеийнхээ өмнө зайлиггүй хүлээх үүрэг* билээ.